

АГУУЛГА**Тайланг хянасан:****ҮАГ-ын харъяа Хэнтий
аймгийн аудитын газар****Газрын дарга, Тэргүүлэх
аудитор:***Ц.Энхтүвшин***Аудитын менежер:***Б.Наранцэцэг***Тайланг бэлтгэсэн:****Ахлах аудитор:***Х.Еркегүл***Шинжээч:***М.Чулуун-Эрдэнэ***2016 оны 4 дүгээр сар****Уг тайланг ҮАГ-ын
Цахим хуудаснаас үзнэ үү:**
www.audit.mn*Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70562112 дугаарын
утасаар харилцана уу.***ХАЯГ:***Үндэсний аудитын газрын
харъяа Хэнтий аймгийн
аудитын газар.
Аймгийн ЗДТГ,
Тэмүүжингийн гудамж,
Хэнтий аймаг-23110
Монгол Улс*

Товчилсон үгийн жагсаалт3

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....6

Аудитын зорилт, хамарсан хүрээ.....6

Аудитын арга зүй.....6

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланг
нэгтгэхэд

баримталсан бодлого, аргачлал.....6

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт7

Гурав. Шилэн дансны мэдээлэл.....7

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....8

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....8

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар9

6.2 Банкин дахь Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харилцах дансны талаар
.....10

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1. Авлагын бүтэц, дамжуулан зээлийн авлагын талаар.....12

7.2. Авлагатай холбоотой зөрчлийн талаар14

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар15

8.2 Төсөл, сангийн бараа материал дансны талаар.....16

8.3 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар.....16

8.4 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын
бараа материалтай холбоотой зөрчлийн талаар.....16

Ёс. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....18

9.2 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын
үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар.....20

Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын

10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар21

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын
талаар.....2210.3 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн ЗДТГ-уудад олгосон
дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн талаар.....23

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар	23
11.2 Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан..	24
Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал	
12.1 Зардлын бүртгэлийн талаар	25
12.2 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар.....	28
12.3 Зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар.....	28
12.4 Хуримтлагдсан үр дүнгийн талаар	32
12.5 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар	32
Арван тав. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар.....	32
Арван зургаа. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....	37
Арван долоо. Тайлант оны аудитын зөвлөмж.....	37

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
АХБ	Азийн хөгжлийн банк
АХС	Аймаг хөгжүүлэх сан
БЗД	Багийн засаг дарга
БСГ	Боловсрол соёлын газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗДНС	Засаг даргын нөөцийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НААХС	Нийтийн аж ахуйг хөгжүүлэх сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмчит үйлдвэрийн газар
ОНСНТ	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнсанхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХО	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнхөрөнгө оруулалт
ОНХОС	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнхөрөнгө оруулалтын сан
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
САГ	Санхүүгийн аудитын газар
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СС	Сангийн сайд
ССАЖС	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон Хэнтий аймгийн ТЕЗ-ийнөмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТСГ	Төрийн сангийн газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБҮ	Уулын баяжуулах үйлдвэр
УЗ	Улаан загалмай
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УУС	Уул уурхайн сайд
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар

ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ХАА	Хөдөө аж ахуй
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХС	Эрчим хүчний сайд

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газрын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Хэнтий аймгийн төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хэнтий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Үндэсний аудитын газрын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу 13 сумын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Төсвийн тухай хуулийн 54.1-54.4 заалт, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Төсвийн тухай хуулийн 26.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруз суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- Сумын Төсвийн ерөнхийлөн захирагчдын 23 санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Орон нутгийн төсөвт 131 байгууллагуудын 2015 оны санхүүгийн тайлан

- Тусгай зориулалтын шилжүүлгийн 112 байгууллагын 2015 оны санхүүгийн тайлан
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн 34 газрын 2015 оны санхүүгийн тайлан
- 98 Төсөл, сангуудын 2015 оны санхүүгийн тайлан

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Хэнтий аймгийн ТЭЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Хэнтий аймгийн ТЭЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас урт хугацаат өглөгийн дэлгэрэнгүй тайлан болон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Plastic 1.0” програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Тайлант онд Төсвийн тухай хууль бүрэн хэрэгжиж эхэлснээр төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий санхүүгийн хяналт аудитын алба байгуулагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэ” гэж заасныг баримтлан Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2015 онд зарим сумдын 2014, 2015 оны эхний хагас жилийн санхүүд дотоод аудит хийж, төсвийн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилтийн дүнд нийтлэг илэрсэн зөрчил дутагдалыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дотоод хяналтын эрсдэл “Хэвийн” гэж үнэлэгдсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Шилэн дансны тухай” хуулийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журамын 8.3 заалтыг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хугацаанд нь тавьж байгаа эсэх болон мэдээллийн үнэн зөв бодитой байдалд сүлжээгээр тандан судлах, хяналт хийх удирдамж боловсруулан ажиллажээ.

231 байгууллагаас 2016 оны эхний 3 сарын байдлаар мэдээлэл оруулсан ТЕЗ-ийн 22 байгууллага 11 төрлийн мэдээлэл оруулахаас мэдээллийг хугацаанд нь байршуулсан 68.9 хувь, хугацаа хоцроон байршуулсан 26.9 хувь, огт байршуулаагүй 4.5 хувь, төрийн өмчийн болон төсвийн 209 байгууллага мэдээлэл оруулахаас 79 хувь нь хугацаандаа байршуулсан, 10 хувь нь хугацаа хоцроосон, 11 хувь нь огт байршуулаагүй дүн гарчээ.

Шалгалтын дүнг албан байгууллагын удирдлагын хуралд танилцуулж мэдээллийг хугацаанд нь оруулаагүй болон мэдээлэл огт оруулаагүй байгууллагын удирдлагуудад сануулах арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна.

ЗГ-ын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1 дэх заалтын дагуу “ Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр ТЕЗ-ийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэсэн заалт хэрэгжүүлж эхлээд байна.

Хэдийгээр Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж ажилладаг боловч аудитад хамрагдсан байгууллага, этгээд нь мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулдаггүй, хагас дутуу оруулдаг, эсвэл байхгүй гэж мэдээлдэг, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг оруулдаггүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчил дутагдал нийтлэг байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2015 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 953,3 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх Орон нутгийн төсөвт байгууллага, Төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Төсөл, сангуудын нэгтгэлийн дүнг тус тусад нь баганаар харуулжээ.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Гэвч Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл байхгүйгээс эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах боломжгүй байлаа.

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу УАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газарт санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн

хугацаанд нь эксэл файл, болон цаасан хэлбэрээр ирүүлсэн бөгөөд СТАУС програмд оруулж уялдааг шалгахад зөрүүгүй таарч байна.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн болон гадаад валютаарх харилцах дансдын үлдэгдэл, замд яваа мөнгөн хөрөнгө,
- Кассад байгаа бэлэн мөнгө.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2014 оны эцэст 1970,4 сая төгрөг байснаас 11,9 хувиар өсч 2152,4 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 4,6 хувь буюу 99,1 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2015 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Кассад байгаа бэлэн мөнгө	5.9	6.1	0.2	3.4
Төгрөг/ЖМС	5.9	6.1	0.2	3.4
Нэмэлт санхүүжилтийн Касс			-	
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,964.5	2,146.3	181.8	8.5
Төгрөг	1,964.5	2,146.3	181.8	8.47
Төрийн сангийн харилцах	1,854.7	2,047.2	192.5	10.4
Арилжааны банкин дахь харилцах	109.8	99.1	(10.7)	(9.7)
Гадаад валют				
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1,970.40	2,152.40	182.00	11.86
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	1,064.60	1,228.80	164.2	15.4

Нэмэлт санхүүжилтийн сан		94.2		
Төсөвт байгууллагууд	29.90	339.00	309.1	1,033.8
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	112.40	58.80	(53.60)	(47.69)
Төсөл, сангууд	763.40	420.40	(343.0)	(44.9)

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал: Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 309,1 сая төгрөгөөр, төрийн сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 164,2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тайлант онд ОН-ын татварын орлого 499,9 сая төгрөг, татварын бус орлого 137,1 сая төгрөг, нийт 637,0 сая төгрөгөөр давж биелэгдсэн болон ОН-ын төсвийн зарлагын гүйцэтгэл 2306,0 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсантай холбоотой байна.

6.2 Банкин дахь Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харилцах дансны талаар

Сангийн яамны Төрийн сангийн газраас Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу Монголбанк, банкинд төсвийн байгууллагын дансыг нээх, хаах, улсын төсвийн орлогын “тэг” үлдэгдэлтэй данс байршуулах зөвшөөрөл олгох харилцааг зохицуулах зорилгоор “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам”-ыг шинээр боловсруулан Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дүгээр хамтарсан тушаалаар батлуулан мөрдөн ажилласан байна.

Сангийн яамны Төлбөр тооцооны хэлтэс Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкуудаас ирүүлсэн “Засгийн газрын нэгдсэн дансны мэдээ”-г үндэслэн Төрийн сангийн данс болон банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг Төсвийн захирагчдын дансанд баталгаажуулалт хийхэд 2 дансанд 11,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь цалингийн дансанд ажиллагсдын цалингийн зээлийг ХААН банк татан төвлөрүүлээгүй буюу үлдснийг 2016 оны 1 сарын 2-ны өдөр татан төвлөрүүлсэн байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансыг Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвөөр хураангуйлан харуулбал:

ХЭНТИЙ АЙМАГ	Үлдэгдэл				НИЙТ ДАНСНЫ ТОО	
	Хэнтий аймгийн ТЕЗ-ийнхаламж	Хэнтий аймгийн ТЕЗ-ийн өмчит үйлдвэрийн газар	Цалин	НИЙТ үлдэгдэл /сая.төг/	Байгаа	Хаагдсан
Галшир сум	0.00	0.10	0.00	0.10	3	0
Баянхутаг сум	0.00	0.11	11.20	11.31	4	0
Баянмөнх сум	0.00	0.05	0.00	0.05	5	1
Дархан сум	0.00	0.03	0.00	0.03	4	0
Дэлгэрхаан сум	0.00	0.06	0.00	0.06	5	0
Жаргалтхаан сум	0.00	0.11	0.00	0.11	4	0
Цэнхэрмандал сум	0.00	0.04	0.00	0.04	4	0
Өмнөдэлгэр сум	0.00	16.78	0.00	16.78	6	0
Батширээт сум	0.00	5.78	0.00	5.78	6	0

Биндэр сум	0.00	4.16	0.00	4.16	6	0
Баянадрага сум	0.00	3.21	0.00	3.21	4	1
Дадал сум	0.00	0.01	0.00	0.01	3	0
Норовлин сум	0.00	0.27	0.00	0.27	4	0
Батноров сум	0.00	0.59	0.00	0.59	3	0
Баян-Овоо сум	0.00	0.02	0.00	0.02	3	0
Мөрөн сум	0.00	0.05	0.00	0.05	4	0
Хэрлэн сум	29.88	16.60	0.00	46.48	14	0
Гурванбаян тосгон	0.00	0.00	0.00	0.00	3	0
Бор-Өндөр сум	0.00	7.53	0.00	7.53	5	0
Өлзийт тосгон	0.00	0.01	0.00	0.01	3	0
Бэрх тосгон	0.00	0.58	0.00	0.58	3	0
Хэрлэн баян улаан тосгон	0.00	0.00	0.00	0.00	0	0
Аймгийн Төрийн сан	0.00	1.93	0.00	1.93	10	0
НИЙТ ДҮН	29.88	58.02	11.20	99.10	106.00	2.00

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчиж, Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр Баянмөнх сумын ТЕЗ-ийн 1 байгууллага арилжааны банкинд харилцах данс нээж, гүйлгээ хийж байсныг хаасан, Баян-Адрага сумын байгаль хамгаалах сангийн дансыг төрийн санд байршуулан арилжааны банкин дахь дансыг хаасан байна.

Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг төсвийн байгууллагуудаас хүлээн авсан санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад Бэрх тосгоны төрийн сангийн харилцахын үлдэгдэл 1 төгрөгөөр, Норовлин сумын төрийн сангийн харилцах 0,50 мөнгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 37,8 сая төгрөгийн зөрчил илэрч, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэглийг хангаагүй байн. Үүнд:

- Аймгийн ИТХ кассаас 3,6 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан
- ГХБХБГазрын дарга удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр төсвөөс 850,0 төгрөгийг өөрөө өөртөө тушаал гарган зарцуулсан
- Бор-Өндөр сумын ЗДТГ 25,6 сая төгрөгийг, ИТХ 1,7 сая төгрөгийн төсвийн төвлөрүүлсэн үлдэгдлийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасаж илэрхийлээгүй

- Мөн Бор-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор баталсан туршлага судлах зориулалтаар 6,0 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

Үүнээс 9,6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 0,9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч 27,3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 8437,0 сая төгрөг байснаас тайлант онд 265,2 сая төгрөгөөр буюу 3,1 хувиар буурч, оны эцэст 8171,8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	9.5	3.6	(5.9)	(62.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	175.1		(175.1)	(100.0)
Дансны авлага /ТӨҮГ/		263.2	263.2	
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/		0.2	0.2	
Байгууллагаас авах авлага	1,053.6	635.4	(418.2)	(39.7)
Хувь хүмүүсээс авах авлага	7,120.6	7,239.4	118.8	1.7
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	78.2	30.0	(48.2)	(61.6)
НИЙТ ДҮН	8,437.0	8,171.8	(265.2)	(3.1)
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	78,2	30,0	(48,2)	(61.64)
Төсөвт байгууллагууд	336.2	125.5	(210,7)	(62.67)
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	266.8	460.9	194.10	72.75
Төсөл, сангууд	7755,8	7555,4	(200,4)	(2,58)

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төлбөртэй үйлчилгээний авлагыг 2015 онд дансны авлага дансанд нэгтгэсэн байна. Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 0,3 хувийн төрийн сан, 1,5 хувийг төсөвт байгууллага, 5,6 хувийг ОНӨҮГ, 92,4 хувийг төсөл, сангийн авлага буюу СХС, ЖДҮДС-аас


олгосон зээлийн авлага эзлэж байна. Төрийн сан, төсөвт байгууллагын авлага буурсан нь орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагын нэмэлт дансны үлдэгдлийг буцаан олгосонтой холбоотой юм:

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Аймгийн нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Галшир сум	265.6	266.90	1.30	0.5
Баянхутаг сум	277.7	266.90	-10.80	-3.9
Баянмөнх сум	293.2	298.30	5.10	1.7
Дархан сум	164.5	168.70	4.20	2.6
Дэлгэрхаан сум	275.2	269.70	-5.50	-2.0
Жаргалтхаан сум	248.9	254.10	5.20	2.1
Цэнхэрмандал сум	297.4	326.50	29.10	9.8
Өмнөдэлгэр сум	322.3	330.90	8.60	2.7
Батширээт сум	296.2	301.50	5.30	1.8
Биндэр сум	309.2	323.40	14.20	4.6
Баянадрага сум	263.1	276.00	12.90	4.9
Дадал сум	277.8	281.70	3.90	1.4
Норовлин сум	305.9	297.30	-8.60	-2.8
Батноров сум	293.5	279.40	-14.10	-4.8
Баян-Овоо сум	276.8	261.70	-15.10	-5.5
Мөрөн сум	243.4	276.10	32.70	13.4
Хэрлэн сум	1514.9	1,500.10	-14.80	-1.0
Гурванбаян тосгон	52.2	54.70	2.50	4.8
Бор-Өндөр сум	915.6	901.70	-13.90	-1.5
Өлзийт тосгон	9.5	6.10	-3.40	-35.8
Бэрх тосгон	267.6	274.10	6.50	2.4
Хэрлэн баян улаан тосгон	11.1	11.10	0.00	0.0
Аймгийн Төрийн сан	1254.4	944.80	-309.60	-24.7
Нийт дүн	8436	8,171.70	-264.30	-29.3

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны нийт авлагын үлдэгдэлийг сум тус бүрээр графикаар харуулбал:



7.2 Авлагатай холбоотой зөрчлийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой нийт 55,8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй буюу үнэн зөв байдал, толилуулга, эрх ба үүрэг, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэглийг хангаагүй, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааварыг зөрчсөн байна. Үүнд:

- Он дамжсан олон жилийн насжилттай 0,5 сая төгрөгийн авлага
- Санхүүгийн тайланд тусгасан 14,0 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж актаар баталгаажуулалгүйгээр санхүүгийн тайланд тусгасан.
- Санхүүгийн болон тодруулгын тайланд зөрүүтэй тайлагнасан 15,2 сая төгрөгийн авлага
- Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд тусгалгүй орхигдуулсан 26,1 сая төгрөгийн авлага зэрэг болно.

/Зөрчлийг доорх хүснэгтээс харна уу/

(мянган төгрөгөөр)

д/ д	Сумын нэр	Байгууллагын нэр	Насжилт өндөр	Баталгаажуулагүй		Залруулсан			Тайланд тусгаагүй
			Аудитаар авсан арга хэмжээ						
			Зөвлөмж	Зөвлөмж	Албан шаардлага	Залруулсан	Зөвлөмж	Албан шаардлага	Зөвлөмж
1	Хэрлэн сум	Тахилгат ЗАА		3,121.1					
2	Хэрлэн сум	ЗДТГ		3,626.8					
3	Батноров сум	ТТЗ		900.0					
4	Баян-Овоо сум	ТТЗ		100.0					
5	Галшар сум	ТТЗ		900.0					
6	Аймаг	БОАЖГАзар			4,155.0				
7	Баянмөнх сум	ЗДТГ			625.7				

8	Бор-Өндөр сум	ЗДТГ			400.0				
9	Бор-Өндөр сум	ЗДТГ				11,683.1			
10	Бор-Өндөр сум	ИТХ			228.6				
11	Бор-Өндөр сум	ИТХ				159.5			
12	Бор-Өндөр сум	Бор-Өндөр хот тохижилт ОНӨҮГ						926.1	
13	Дархан сум	ЗДТГ				165.0			
14	Жаргалтхаан сум	ЗДТГ	400.0						
15	Жаргалтхаан сум	Соёлын төв	125.0						
16	Жаргалтхаан сум	Сургууль					270.0		
17	Норовлин сум	ЗДТГ				1,058.4			
18	Өмнөдэлгэр сум	ЗДТГ				918.8			
19	Аймаг	ИТХ							26,108.5
			525.0	8,647.9	5,409.3	13,984.8	270.0	926.1	26,108.5
Нийт дүнгээр			55,871.6						

Найм.Бараа материалын бүртгэл, тайлагнал.

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдхүүний талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 3943,2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4486,9 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайланд онд 543,7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт бараа материалын үлдээдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	259.70	295.60	35.9	13.8
Эм боох материал	151.70	146.50	(5.2)	(3.4)
Дуусаагүй үйлдвэрлэл	10	10	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	0.1	0.10	-	-

Бичиг хэргийн материал	111.10	145.30	34.2	30.8
Аж ахуйн материал	1,398.00	1,767.90	369.9	26.5
Сэлбэг хэрэгсэл	61.00	54.90	(6.1)	(10.0)
Түлш шатхуун, тослох материал	87.10	111.00	23.9	27.4
Барилга засварын материал	95.00	79.90	(15.1)	(15.9)
Хүнсний материал	257.90	171.20	(86.7)	(33.6)
Бусад хангамжийн материал	897.20	1,052.70	155.5	17.3
Мал амьтад	614.20	651.70	37.5	6.1
Нөөцийн бараа	31.80	31.80	-	-
НИЙТ ДҮН	3,974.80	4,518.60	543.80	59.00
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
Төрийн сан				
Төсөвт байгууллагууд	3436.2	3699.2	263.00	7.65
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	456.6	720.5	263.90	57.80
Төсөл, сангууд	50.4	67.2	16.80	33.33

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл, аж ахуйн материал 369,9 сая төгрөгөөр, хангамжийн материал 155,5 сая төгрөгөөр, тусгай зориулалтын материал 35,9 сая төгрөгөөр, шатах тослох материал 23,9 сая төгрөгөөр өссөн бол, хүнсний материал 86,7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийт бараа материалын данс 8368,9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 7641,2 сая төгрөгийн, хандив тусламжаар 149,7 сая төгрөгийн, шилжүүлж авсан 155,1 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 422,9 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд нийт бараа материалын дүн 7824,9 сая төгрөгөөр буурснаас 7448,7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан буюу худалдсан, 240,5 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, бусад байдлаар 135,7 сая төгрөгөөр бараа материалын данс буурсан байна.

8.2 Төсөл, сангийн бараа материал дансны талаар

Төсөл сангийн бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 96,5 сая төгрөг байгаагийн 67,1 сая төгрөг буюу 69,5 хувийг Малыг эрсдлээс хамгаалах сан, 29,4 сая төгрөг буюу 30,5 хувийг Газар тариаланг дэмжих сан тус тус эзэлж байна. Төсөл сангийн бараа материал нь 2015 оны нийт бараа материалын үлдэгдэлийн 2,2 хувийг эзэлж байна.

8.3 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар

ОНӨҮГ-ын бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 720,5 сая төгрөг байгаагаас “Хэнтий-ус” ХХК нь 493,3 сая төгрөг буюу 68,4 хувь, үлдэх 227,2 сая төгрөг буюу 31,5 хувийг сумдын ЭЭС болон ойн ангиуд эзэлж байна. ОНӨҮГ-ын бараа материал нь 2015 оны нийт бараа материалын үлдэгдэлийн 57,8 хувийг эзэлж байна.

8.4 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын бараа материалтай холбоотой зөрчлийн талаар

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, буруу бүртгэсэн, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, бараа материалыг анхан шатны баримтгүй болон бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, тушаал шийдвэргүй данс бүртгэлээс хассан зэрэг нийт 46,9 сая төгрөгийн зөрчил илэрч, толилуулга ба тодруулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааварыг зөрчсөн байна. Тухайлбал,

- Хэрлэн сумын Хот тохижилт ОНТҮГазар нь 3,9 сая төгрөгийн АИ92 бензин мөн 5,0 сая төгрөгийн шатахууны талоныг дизель түлш авснаар бүргэж зарлагдсан, Дархан сумын ЗДТГ нь нэг бүрийн үнийг 1 төгрөгөөр тооцон 1379,5 мянган төгрөгийн өвсийг бөөн дүнгээр зарлагдсан, Хан Хэнтий чуулга 2487,0 мянган төгрөгийн шатахууныг нярвын тайланд бөөн дүнгээр орлого авсан, Жаргалтхаан сумын соёлын төвийн бараа материал нь тооллогын бүртгэлээс 19,9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, Өмнөдэлгэр сумын ЭМТ нь 2564,6 мянган төгрөгийн эмийн бараа материалын тайланд орлого авсан боловч эмийн тайланд тайлагнаагүй
- Аймгийн ИТХ-ын даргын шийдвэргүйгээр бараа материалаасаа 5,0 төгрөгийн хөөрөгийг аймгийн музейд шилжүүлсэн, аймгийн ЗДТГ 11835,9 мянган төгрөгийн, Дэлгэрхаан сумын соёлын төв 429,8 мянган төгрөгийн бараа материалыг, Жаргалтхаан сумын сургууль нь 150,0 мянган төгрөгийн малыг анхан шатны баримтгүй, тушаал шийдвэргүйгээр бараа материалын данснаас хассан
- ГХБХБГазар нь 9907,0 мянган төгрөгийн, Жаргалтхаан сумын ИТХ 809,1 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан,
- Баян-Овоо сумын цэцэрлэг 980,0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төв 50,0 мянган төгрөгийн бараа материалыг орлого авалгүй шууд зардалд хаасан
- Бор-Өндөр сумын “Бор-Өндөр цогцолбор сургууль” –ийн бараа материалын хяналтын тооллогоор 2313,8 мянган төгрөгийн хадгалах хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байгаа нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэх болон хүнсний материалын ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 7.7-д “ Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 9.1.5-д “Эд хөрөнгө, өр төлбөрийг хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх”, гэсэн заалтуудыг мөн “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм” –ийг зөрчсөн байна.

/Зөрчлийг доорх хүснэгтээс харна уу/

(мянган төгрөгөөр)

Сумын нэр	Байгууллагын нэр	Дансны нэр	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитаар авсан арга хэмжээ
Хэрлэн сум	Хот тохижилт	Бараа материал	Буруу бүртгэсэн	3,980.50	Зөвлөмж өгөх

Хэрлэн сум	Хот тохижилт	Бараа материал	Буруу бүртгэсэн	5,005.00	Зөвлөмж өгөх
Аймаг	ИТХурал	Бараа материал	Шийдвэргүй	5,000.00	зөвлөмж өгөх
Аймаг	ГХБХБГ	Бараа материал	Анхан шатны баримтгүй	9,907.00	албан шаардлага
Баян-Овоо сум	Цэцэрлэг	Бараа материал	шууд зардалд хаасан	980.00	зөвлөмж өгөх
Баян-Овоо сум	ЭМТ	Бараа материал	шууд зардалд хаасан	50.00	зөвлөмж өгөх
Аймаг	ЗДТГ	Бараа материал	Шийдвэргүй	11,835.90	албан шаардлага
Бор-Өндөр сум	Бор-Өндөр цогцолбор сургууль	Бараа материал	Дотоод хяналт	2,313.80	зөвлөмж
Дархан сум	ЗДТГ	Бараа материал	Буруу бүртгэсэн	1,379.50	залруулсан
Дэлгэрхаан сум	Соёлын төв	Бараа материал	Шийдвэргүй	429.80	албан шаардлага
Аймаг	ХХЧуулга	Бараа материал	Буруу бүртгэсэн	2,487.00	зөвлөмж
Жаргалтхаан сум	ИТХ	Бараа материал	Анхан шатны баримтгүй	809.10	зөвлөмж
Жаргалтхаан сум	Соёлын төв	Бараа материал	Буруу бүртгэсэн	19.90	залруулсан
Жаргалтхаан сум	Сургууль	Бараа материал	Анхан шатны баримтгүй	150.00	зөвлөмж
Өмнөдэлгэр сум	ЭМТ	Бараа материал	Буруу бүртгэсэн	2,564.60	зөвлөмж
Дүн				46,912.10	

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2014 оны эцэст 3,949.0 сая төгрөг байсан бол тайлант онд 15.2 хувь буюу 599.9 сая төгрөгөөр нэмэгдэж 2015 оны эцэст 4,548.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			дүн	Хувь
Газар	364.6	364.6	0	0
Барилга байгууламж	64,803.20	71,858.50	7055.3	10.9
Тээврийн хэрэгсэл	3,199.50	2,968.80	-230.7	(7.2)
Машин тоног төхөөрөмж	4,987.40	5,676.30	688.9	13.8
Тавилга эд хогшил	2,778.60	2,615.90	-162.7	(5.9)
Дуусаагүй барилга	17,460.60	16,138.50	-1322.1	(7.6)
Зам, гүүрийн байгууламж	5,181.70	4,745.70	-436	(8.4)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,373.00	1,611.90	238.9	17.4
Бусад үндсэн хөрөнгө	3,136.30	3,262.30	126	4.0
Ном	740.90	734.80	-6.1	(0.8)

Биет бус хөрөнгө	96.20	80.10	-16.1	(16.7)
Дүн	104,122.00	110,057.40	5,935.40	5,70
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан				
Төсөвт байгууллагууд	97110.7	102830.2	5,719.50	5.89
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	3993.5	7226.4	3,232.90	80.95
Төсөл, сангууд	17.8	0.7	-17.10	(96.07)

Нийт үндсэн хөрөнгө өмнөх оноос 5.7 хувиар өссөн байна. Үүнд: барилга байгууламж 10.9 хувь, машин тоног төхөөрөмж 13.8 хувь, түүх соёл, музейн дурсгал зүйл 17.4 хувиар өссөн бол тээврийн хэрэгсэл 7.2 хувь, тавилга, эд хогшил 5.9 хувь, зам гүүрийн байгууламж 8.4 хувь, биет бус хөрөнгө 16.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Байгууллагын төрлөөр авч үзвэл ОНӨҮГ-уудын үндсэн хөрөнгө өмнөх оноос 81 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 16,934.7 сая төгрөгөөр /үүний дотор худалдан авсан 735.3 сая төгрөг, хандив тусламжаар 816.9 сая төгрөг, шилжүүлж авсан 3,213.1 сая төгрөг, дахин үнэлгээгээр 16.0 сая төгрөг, бусад 000000 сая төгрөг / нэмэгдэж, 6,585.2 сая төгрөгөөр /үүний дотор худалдсан 81,5 сая төгрөг, акталсан 1,198.7 сая төгрөг, шилжүүлсэн 3,255.1 төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр 4.7 сая төгрөг, бусад 2045.2 сая төгрөг/ хасагдаж, тайлант онд 5,797.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд барилга байгууламж 7,055.3 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 688.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгин хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна. Түүх соёл, музейн дурсгал зүйл 238.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд дахин үнэлгээ хийж, бүртгэлгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Нийт үндсэн хөрөнгийн 0.3 хувийг газар, 65.3 хувийг барилга байгууламж, 2.4 хувийг тавилга, эд хогшил, 5.2 хувийг машин тоног төхөөрөмж, 14.7 хувийг дуусаагүй барилга, 4.3

хувийг зам гүүрийн барилга байгууламж, 2.7 хувийг тээврийн хэрэгсэл, 5.2 хувийг биет бус болон бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

9.2 Сумдын ТЭЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой 183,1 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хариуцна”, 11.2.1-д “Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллого хийнэ”, 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх...” гэсэн заалтуудыг зөрчиж, хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй нийт 143,7 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд оршин байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг зөчрсөн байна. Үүнд:

- БОАЖГазар 139,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллогыг хийж, баталгаажуулаагүй;
- Батноров, Баян-Овоо, Галшар сумын ТЭЗ, Жаргалтхаан сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв болон Өмнөдэлгэр сумын соёлын төв нь төсвийн тухай хуулинд заасны дагуу тооллогыг явуулсан боловч тооллогоор зөрүүтэй гарсан үр дүнг удирдлага болон өмч хамгааах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлээгүй,
- Дадал сумын ЕБСургуулийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,5 сая төгрөгийн микроавтобус биетээр байхгүй,

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү ИТХ, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчин холбогдох байгууллагын зохих шийдвэргүйгээр нийт 3,1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд:

- Дадал сумын ИТХ 1,9 сая төгрөгийн 50 инчийн 3D телевизор, 1,2 сая төгрөгийн нотебүүк буюу нийт 3,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг зохих шийдвэргүйгээр бэлтгэсэн
- ГХБХБГазар нь нэмэлт санхүүжилтийн данснаас 5,3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны харилцахаас 6,3 сая төгрөг буюу нийт 11,7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан
- Аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөөс 2441,0 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨХ-ны шийдвэргүй анхан шатны баримтгүй данснаас хассан

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Санхүүгийн тайлан нь үнэн зөв, баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж үндсэн хөрөнгийн элэгдлийг нийт 257.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Хэрлэн сумын Тахилгат тосгоны ЭМТ нь ашиглалтад авсан үндсэн хөрөнгийн 18,7 мянган төгрөгийн элэгдлийг байгуулаагүй,
- Баямөнх сумын Соёлын төв 392,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн,
- Бор-Өндөр сумын Энхжин цэцэрлэг, Дархан сумын ЕБС нь хүчингүй болсон ЗГ-ын 233-р тогтоолоор элэгдлээ тооцсон

- Норовлин сумын ЗДТГ-ийн үндсэн хөрөнгөд багийн хөрөнгийг шилжүүлэхдээ 6658,4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд тусгаагүй байна.
- Норовлин сумын ЭМТ нь 15,0 сая төгрөгийн хандив тусламжийн хөрөнгөөр эмнэлгийн хашаа барьж орлого авсан боловч хөрөнгийг хүлээн авсан акт үйлдээгүй байна.

Арав.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 349,716.1 сая төгрөг байснаас тайланд онд 74,748.0 сая төгрөгөөр өсч, оны эцэст 424,464.1 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Богино хугацаат өр төлбөр	758.1	1,850.1	1,092.0	144.0
Богино хугацаат зээлийн өглөг	194.4	127.3	(67.1)	(34.5)
Өглөг	563.7	1,722.8	1,159.1	205.6
Урьдчилж орсон орлого	-	-	-	-
Урт хугацаат өр төлбөр	2,040.2	2,040.2	-	-
Урт хугацаат үнэт цаас	-	-	-	-
Урт хугацаат зээл	2,040.2	2,040.2	-	-
Нийт өр төлбөрийн дүн	2,798.3	3,890.3	1,092.0	39.0

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөр 1,092.0 сая төгрөгөөр буюу 39 хувиар өссөн байна. Нийт өр төлбөрийн 47.6 хувийг богино хугацаат өр төлбөр, 52.4 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр задалж харуулбал:

/сая төгрөг/

д/д	Аймгийн нэр	Нийт өр төлбөр		Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ХБУлаан	4.3	3.3	-1.0	0.1
2	Цэнхэрмандал	3.4	5.3	1.9	0.1
3	Дэлгэрхаан	8.7	11.3	2.5	0.3
4	Мөрөн	7.9	12.8	4.8	0.3

5	Баян-Адарга	5.6	13.0	7.4	0.3
6	Өлзийт	10.6	14.9	4.2	0.4
7	Дадал	13.4	15.4	2.0	0.4
8	Баян-Овоо	23.0	17.0	-6.0	0.4
9	Батноров	1.8	17.3	15.5	0.4
10	Галшар	13.4	19.0	5.6	0.5
11	Дархан	6.1	20.1	14.0	0.5
12	Баянхутаг	11.0	20.5	9.6	0.5
13	Баянмөнх	10.5	20.9	10.4	0.5
14	Гурванбаян	2.9	24.8	21.9	0.6
15	Жаргалтхаан	7.9	26.5	18.6	0.7
16	Биндэр	25.9	28.6	2.7	0.7
17	Батширээт	3.6	29.5	25.9	0.8
18	Өмнөдэлгэр	10.8	31.6	20.8	0.8
19	Норовлин	10.6	32.0	21.5	0.8
20	Бэрх	9.3	60.3	51.0	1.6
21	Бор-Өндөр	59.8	186.4	126.6	4.8
22	Хэрлэн	44.8	226.6	181.8	5.8
23	Аймгийн төв	2,502.9	3,053.0	550.1	78.5
	Дүн	2,798.3	3,890.3	1,092.0	100.0

Хүснэгтээс үзэхэд тайлант оны эцэст нийт өр төлбөрийн 3053.0 сая төгрөг буюу 78.5 хувь нь аймгийн, 226.6 сая төгрөг буюу 5.8 хувь нь Хэрлэн сум, 186.4 сая төгрөг буюу 4.8 хувь нь Бор-Өндөр сум, 10.9 хувь нь бусад сумдад оногдож байна.

Аймаг, сумын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 39.4-т “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өглөгийг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй, бараа, ажил үйлчилгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж актаар баталгаажуулалгүйгээр санхүүгийн тайлан, бүртгэлд тусгасан зэрэг нийт 41,8 сая төгрөгийн зөрчил илэрч, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэглийг хангаагүй байна. Үүнд:

- Баян-Овоо сумын ЗДТГ нь ажиллагсадад түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо 1,5 сая төгрөгийн НДШ-ийг төсөвт төвлөрүүлээгүй, цэцэрлэгийн ажиллагсдын цалинг НД-ийн тайланд дутуу тайлагнаснаас 138,6 мянган төгрөгийг НДШ-ийн өглөгийг төсөвт төвлөрүүлээгүй
- Дадал сумын ЕБС нь хоолны зардлаар өглөггүй байхад 7,5 сая төгрөгийг өглөг гэж буруу тайлагнасан
- Баянмөнх сумын ЗДТГ 34,5 мянган төгрөгийн ХХОАТ-ын, соёлын төв 47,8 мянган төгрөгийн НДШ-ийн, Норовлин сумын ЗДТГ 120,3 мянган төгрөгийн НДШ-ийн, сургууль 3,0 сая төгрөгийн цахилгааны төлбөрийн өглөгийг, Өмнөдэлгэр сумын ЭМТ 186,7 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан.
- Батноров сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,6 сая төгрөгийн, Баян-Овоо сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 6,1 сая төгрөгийн, Галшар сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 7,4 сая төгрөгийн, БОАЖГазар 6,5 сая төгрөгийн, Бор-Өндөр сумын соёлын төв 0,6 сая төгрөгийн, ХГБХХэлтэс 1,2 сая төгрөгийн буюу нийт 23,5 сая төгрөгийн өглөгийн тооцоог харилцагч байгууллагуудтай нийлж баталгаажуулалгүйгээр санхүүгийн тайлан, бүртгэлд тусгасан.
- Баян-Овоо сумын ИТХ 0.7 сая төгрөгийн, соёлын төв 2,8 сая төгрөгийн, ЗДТГ 2,2 сая төгрөгийн, Хэрлэн сумын соёлын төв 0.09 сая төгрөгийн ажил гүйлгээг өглөгийн тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд хаасан

Аймгийн аудитын газраас 8,5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 21,2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 1,7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Дээрх байдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-т “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах”, 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус хангахгүй байна.

10.3 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн ЗДТГ-уудад олгосон дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн талаар

Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн Хэнтий аймгийн ТЕЗ-ийн зээлийг авч үзвэл Азийн хөгжлийн банкнаас авсан нэгтгэсэн тайланд Хэнтий-ус ХХК"-ний санхүүгийн тайланд 2040.2 сая төгрөгийн урт хугацаат зээл бүртгэлтэй байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар

2015 оны Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 101,823.8 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 22,250.0 сая төгрөгөөр буурсан байна.

/сая төгрөг/


Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
Татварын орлого	6,826.23	8,041.60	1,215.37	17.80
Татварын бус орлого	40,182.40	29,164.83	(11,017.57)	(27.42)
Тусламж санхүүжилтийн орлого	77,065.19	64,617.40	(12,447.79)	(16.15)
Үйл ажиллагааны орлогын дүн	124,073.82	101,823.83	(22,249.99)	(17.93)

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого 1,215.4 сая төгрөг буюу 17.8 хувиар өссөн бол татварын бус орлого 11,017.6 сая төгрөг буюу 27.4 хувиар, тусламж санхүүжилтийн орлого 12,447.8 сая төгрөг буюу 16.2 хувиар буурсан байна. Түүний дотор улсын төсвийн санхүүжилт 736,308.5 сая төгрөгөөр, Хэнтий аймгийн ТЕЗ-ийн төсвийн санхүүжилт 170,573.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

11.2 Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд нийт 22 сум, аймгийн төрийн сангийн 101823,8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна.

Нийт орлогын дүнд эзлэх хувийн жинг сумдуудаар харуулбал



Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар орлогыг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй, өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй зэрэг нийт 51,2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Хэрлэн сумын ЗДТГ 767,8 мянган төгрөгийн, Бор-Өндөр сумын Бор-Өндөр хот тохижилт ОНӨҮГ 448,1 мянган төгрөгийн, Аймгийн ЗДТГ 577,8 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй
- Баянмөнх сумын Соёлын төв төсвийн төвлөрүүлсэн үлдэгдэл 150,3 мянган төгрөгийг, ИТХ 1944,8 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасаж илэрхийлээгүй,
- Дадал сумын сургууль 800,0 мянган төгрөгийн хандивын орлогыг, цэцэрлэг 200,0 мянган төгрөгийн хандивын орлогыг, Эрүүл мэндийн төвд ЭМЯ-с шилжүүлсэн 11050,5 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг тайланд хөрөнгийн орлогоор бүртгэж тайлагнасан
- Норовлин сумын ИТХ 4409,8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогыг үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн, цэцэрлэг хандив тусламжийн 19235,4 мянган төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны орлогоор бүртгэж тайлагнасан
- Дадал сумын Соёлын төв 30,0 мянган төгрөгийн өөрийн орлогыг касст тушаалгүй ажилтандаа буцалтгүй тусламж хэлбэрээр буцаан олгосон.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг биелүүлсэн боловч үндсэн үйл ажиллагааны орлого тасарсан сумдууд байна. Тухайлбал,

- Цэнхэрмандал сумын Соёлын төв 219,5 мянган төгрөгөөр,
- Аймгийн ЗДТГ 2853,6 мянган төгрөгөөр
- Баянмөнх сум ЗДТГ 348,0 мянган төгрөгөөр
- Бор-Өндөр сум Соёлын төв 486,6 мянган төгрөгөөр
- АДБ-гийн Хан Хэнтий Чуулга 5600,0 мянган төгрөгөөр
- Жаргалтхаан сумын ЗДТГ 669,5 мянган төгрөгөөр
- Жаргалтхаан сумын Соёлын төв 1400,0 мянган төгрөгөөр тус тус орлого тасарсан байна.

Дээрх байдал нь Төвсийн тухай хуулийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах” заалтыг зөрчсөн байна.

Аймгийн аудитын газраас 1,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 38,2 сая төгрөгийн зөрчийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1 Зардлын бүтцийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 91828,8 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 5569,7 сая төгрөгөөр буурсан байна.

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны төсвийн нийт зарцуулалтыг үр дүнгийн тайланд тайлагнасны дагуу нийт зардлыг эдийн засгийн ангиллаар өмнөх болон тайлант оны зардлын эзлэх хувийг хүснэгт №1, график №1-ээр харуулав.

Нийт зардлыг бүтэцээр нь харуулбал:

Хүснэгт №1 /сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,398.60	91,829.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	97,398.60	91,829.00	100.0
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,400.70	47,857.50	52.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	25,192.00	26,535.20	28.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,206.60	2,919.00	3.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,295.10	3,524.40	3.8
Хангамж, бараа материалын зардал	1,383.70	1,264.10	1.3
Нормативт зардал	2,420.30	2,338.00	2.5
Эд хогшил, урсгал засварын зардал	505.90	444.10	0.5
Томилолт, зочны зардал	295.50	184.70	0.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,594.40	1,477.00	1.6
Бараа үйлчилгээний бусад зардал	6,507.20	9,171.00	9.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,551.70	10,150.50	11.1
ТАТААС	0.00	150.40	0.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,446.20	33,670.60	36.7

График №1 /сая төгрөгөөр/



Дээрх хүснэгт №1, график №1-ээс харахад нийт зардлаас хамгийн өндөр хувийг эзэлж байгаа зардлууд нь цалингийн зардал 26535,2 сая төгрөг буюу 28,8 хувь, хөрөнгийн зардал 10150,5 сая төгрөг буюу 11,1 хувь, урсгал шилжүүлэг 33670,6 сая төгрөг буюу 36,7 хувийг тус тус эзэлж байна.


Сумдын зардлыг харьцуулбал:

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

Д/Д	СУМ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
-----	-----	----------	------------	------------

1	Галшир	2,496.10	1,785.40	1.94
2	Баянхутаг	2,997.20	1,471.70	1.60
3	Баянмөнх	1,791.20	1,695.00	1.85
4	Дархан	1,952.10	1,656.90	1.80
5	Дэлгэрхаан	2,004.80	1,884.70	2.05
6	Жаргалтхаан	2,221.10	1,722.50	1.88
7	Цэнхэрмандал	2,044.80	1,743.50	1.90
8	Өмнөдэлгэр	3,522.30	2,953.90	3.22
9	Батширээт	2,272.60	1,957.20	2.13
10	Биндэр	2,751.50	2,393.00	2.61
11	Баянадрага	2,245.00	1,890.50	2.06
12	Дадал	2,963.10	2,044.80	2.23
13	Норовлин	2,868.10	1,885.00	2.05
14	Батноров	2,547.30	2,346.70	2.56
15	Баян овоо	1,980.00	1,787.10	1.95
16	Мөрөн	1,832.70	1,609.40	1.75
17	Хэрлэн	14,255.20	11,685.60	12.73
18	Гурванбаян	1,203.70	1,138.20	1.24
19	Бор Өндөр тосгон	5,106.00	4,507.00	4.91
20	Өлзийт	1,222.40	1,137.70	1.24
21	Бэрх тосгон	2,319.60	2,105.70	2.29
22	Хэрлэн баян улаан тосгон	662.50	613.50	0.67
23	Төрийн сан	34,139.30	39,814.00	43.36
	Бүгд	97,398.60	91,829.00	100.00

График №2 /сая төгрөгөөр/




Дээрх хүснэгт №2, график №2-ээс харахад нутаг дэвсгэр, хүн ам, эдийн засгийн статусаар ялгаатай тул Хэнтий аймгийн Төрийн сан, Хэрлэн сум, Бор-Өндөр сум бусад бусад сумдаас өндөр зарцуулалттай байна. Харин зардлын гүйцэтгэлээр өмнөх оноос Хэнтий аймгийн төрийн сан 5674,2 сая төгрөгөөр буюу 16,6 %-иар өссөн, бусад сумдын хувьд буурсан үзүүлэлттэй байна.

12.2 Хэнтий аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Хэнтий аймгийн ТЭЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу, төсвийг зориулалт бусаар, үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан, холбогдох шийдвэргүй зэрэг нийт 423,6 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрч үнэн зөв байдал, толилуулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэглийг хангаагүй байна.

■ Хэнтий аймгийн ТЭЗ-ийн СНТ-д хийсэн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийг эдийн засгийн ангилалаар ангилж график №4-т дүрслэн харуулав. Хамгийн өндөр хувьтай шууд зардалд хаасан зөрчил 169,0 сая төгрөг буюу 39,8 хувь, үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн, залруулсан НДШ-ийн зөрчил 98,2 сая төгрөг буюу 23,1 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын зөрчил 66,7 сая төгрөг буюу 15,7 хувь, анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу 24,7 сая төгрөг буюу 10,4 хувийг тус тус эзлэж байна.

График №4 /Сая төгрөгөөр/



12.3 Зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Цалин, хангамж, томилолт, эд хогшил, нийгмийн хамгаалал, ээлжийн амралт, тэтгэмж урамшуулал, зочны болон нормативт зардлуудыг зарцуулахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

Бүрдүүлбэр дутуу анхан шатны баримтаар зардал гаргасан:

- Аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулсан 11206,1 мянган төгрөгийн тайлан мэдээ, зарцуулалтын тайлангүй, Дэлгэрхаан сумын ЭМТ нь 1203,0 мянган төгрөгийн, Жаргалтхаан сумын цэцэрлэг 926,0 мянган төгрөгийн, ЭМТ 10342,6 мянган төгрөгийн, Өмнөдэлгэр сумын цэцэрлэг 807,2 сая төгрөгийн, ЭМТ 185,0 мянган төгрөгийн буюу нийт 24,7 сая төгрөгийн зардлыг бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлагдсан
- Аймгийн ИТХ нь 19,0 сая төгрөгийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг олгохдоо төлөөлөгчдөөс үйл ажиллагааны тайлан, зардлын тооцоо гүйцэтгэлийг гаргуулж аваагүй мөн бараа үйлчилгээний бусад зардлаас төсөв тооцоогүй, тушаал шийдвэргүй, ямар хурал зөвөлгөөнд зарцуулсан нь тодорхойгүй 47748,4 мянган төгрөгийн зардлыг гаргаж үр ашиггүй зарцуулсан

Санхүүгийн тайланд зардлыг зөрүүтэй илэрхийлсэн:

- Галшар сумын ЗДТГ 84,6 мянган төгрөгийн цалингийн зардлыг, Аймгийн ЗДТГ 2872,5 мянган төгрөгийн цалингийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд дутуу илэрхийлсэн, Норовлин сумын ЕБС 79,8 мянган төгрөгийн урамшууллыг тайланд зөрүүтэй илэрхийлсэн, Баянмөнх сумын ЭМТ малчны 377,9 мянган төгрөгийн цалинд шимтгэл тооцож тайланд тусгаагүй, Норовлин сумын сургууль санхүүгийн тайланд батлагдсан төсвийг 10300,1 мянган төгрөгөөр, зарцуулалтыг 2019,1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн

Цалингийн зардлаас цалин, урамшуулал илүү олгосон болон зардал гаргасан:

- Тахилагт тосгоны ЗАА 236,5 мянган төгрөгийн, Цэнхэрмандал сумын соёлын төв 93,6 мянган төгрөгийн, Аймгийн ЗДТГ 487,6 мянган төгрөгийн НДШ-ийг цалингийн зардлаас зарцуулсан, Баян-Овоо сумын ЭМТ нь 433,5 мянган төгрөгийн тэтгэмжийг, Дархан сумын сургууль 350,0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг, Норовлин сумын соёлын төв 167,0 мянган төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаас зарцуулсан, Насан туршийн боловсрол төв нь цалингийн урьдчилгаагаар үндсэн хөрөнгө бэлтгэсэн.
- Тахилагт тосгоны ЗАА нь 2 ажилтанд 45,8 мянган төгрөгийн, Цэнхэрмандал сумын ЗДТГ нь 660,3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон, Бор-Өндөр сумын Соёлын төв 4672,6 мянган төгрөгөөр, Дархан сумын ЕБС нь 633,2 мянган төгрөгөөр цалингийн санги батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан,
- Хэрлэн сумын Тахилагт тосгоны ЭМТ нь цалингийн зардлаас 678,1 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон, Өмнөдэлгэр сумын ЗДТГ-ын даргын тушаалаар Засаг дарга 334,1 мянган төгрөгийн урамшуулал авсан

НДШ, ХХОАТ-тай холбоотой зөрчилүүд

- Баян-Овоо сумын сургууль цалингаас 147,0 мянган төгрөгийн, ЭМТ 152,7 мянган төгрөгийн, Бор-Өндөр сум Энхжин цэцэрлэг 116,6 мянган төгрөгийн НДШ-ийг төсөвт төвлөрүүлээгүй,
- Дархан сумын Сургууль 399,0 мянган төгрөгийн, Жаргалтхаан сумын сургууль 184,8 мянган төгрөгийн НДШ-ийг цалингаас дутуу суутгасан
- Бор-Өндөр сумын Соёлын төв 2098,4 мянган төгрөгийн НДШ-ийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогоос хасаж илэрхийлээгүй, Дадал сумын сургууль 6810,9 мянган төгрөгийн, цэцэрлэг 8666,2 мянган төгрөгийн, ЭМТ 3196,0 мянган төгрөгийн, Норовлин сумын сургууль 1719,2 мянган төгрөгийн, цэцэрлэг 3423,8 мянган төгрөгийн, ЭМТ 14619,9 мянган төгрөгийн ХЧТАТэтгэмжийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн,
- Жаргалтхаан сумын сургууль 676,7 мянган төгрөгийн, Өмнөдэлгэр сумын ЭМТ 880,7 мянган төгрөгийн НДШ-ийг дутуу бүртгэсэн
- Дэлгэрхаан сумын ЭМТ 177,9 мянган төгрөгийн, Жаргалтхаан сумын ЭМТ 30191,3 мянган төгрөгийн, Өмнөдэлгэр сумын цэцэрлэг 24700,6 мянган төгрөгийн НДШ-ийг шууд зардалд хаасан
- Баян-Овоо сумын цэцэрлэг 75,6 мянган төгрөгийн, Галшар сумын цэцэрлэг 70,0 мянган төгрөгийн, сургууль 49,0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг илүү тооцож суутгасан, Баян-Овоо сумын ЭМТ 152,1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг баримтгүй суутгасан мөн Галшар сумын ЗДТГ 71,7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлээгүй

Зориулалт бусаар зарцуулсан зардалын талаар

- Аймгийн ЗДТГ-ын нөөц сангаас 265,6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй мөн төсвөөс 670,0 мянгөн төгрөгийг шинэ жилийн баярын арга хэмжээнд зарцуулсан
- Өмнөдэлгэр сумын ЗДТГ-нь засаг даргын нөөц сангаас 4840,0 мянган төгрөгийг баяр наадмын үйл ажиллагаанд зарцуулсан

Томилолтын зардалын талаар

- Аймгийн ИТХ 963,5 мянган төгрөгийн, ОНӨАлба 194,0 мянган төгрөгийн албан томилолтыг хүчин төгөлдөр бус бүрдэл дутуу анхан шатны баримтаар олгосон
- Аймгийн ИТХ 158,8 мянган төгрөгийн, Дадал сумын ИТХ 29,0 мянган төгрөгийн, Өмнөдэлгэр сумын ИТХ 29,0 мянган төгрөгийн томилолтыг илүү олгосон

Тэтгэмжийн зардалын талаар

- Хэрлэн сумын Хот тохижилтын дарга үндэслэлгүй тушаал гаргаж ажилтнаа ажилаас халсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож цалингийн сангаас 8516,4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон мөн Дархан сумын цэцэрлэг цалингийн сангаас 160,0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй
- Баянмөнх сумын ЭМТ нэг удаа олгосон тэтгэмжээс 10,1 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, Дархан сумын цэцэрлэг 130,0 мянган төгрөгний тэтгэмжийг давхардуулан олгосон

Хоол, шатахууны зардлын талаар

- БОАЖГазар нь 926,5 мянган төгрөгийн, Дархан сумын сургууль 871,4 мянган төгрөгийн хоолны зардлыг илүү олгосон
- ХАААлба нь нэг удаагийн шагналын зардлаас 220,0 мянган төгрөгийг хоолны зардалд зориулалт бусаар зарцуулсан
- Жаргалтхаан сумын ИТХ 145,0 мянган төгрөгийн хоолны зардлыг шийдвэргүйгээр, сургууль 718,6 мянган төгрөгийн хоолны зардлын бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлагдсан
- ХГБХХэлтэс нь 880,5 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүй хаана юунд зарцуулсан нь тодорхойгүй

Тушаал шийдвэр, захирамжтай холбоотой зөрчилийн талаар

- Тахилагт тосгоны ЭМТ-ийн эрхлэгч өөртөө тугаал гаргаж 1001,8 мянган төгрөгийн урамшуулалыг, Жаргалтхаан сумын ИТХ-ын даргын захирамжгүйгээр багийн ИНХ-ын дарга нарт 4500,0 мянган төгрөгийн урамшуулалыг, Норовлин сумын ИТХ-ын даргын захирамжаар тэргүүлэгчдэд 2100,0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон
- Дадал сумын Засаг даргын ажилаас чөлөөлөгдсөн шийдвэрийг харгалзаж үзэлгүйгээр ажиллаагүй хугацааны 250,5 мянган төгрөгийн цалинг олгосон
- Тахилагт тосгоны ЭМТ-ийн 4 ажилтан ээлжийн амралтын нийт 45 хоногийн дутуутай ажилдаа орсон бөгөөд ажилд оруулах болон нөхөн амраах тушаал шийдвэр гараагүй, 3,6 сая төгрөгийн ээлжийн амралтын тооцоолол, анхан шатны баримтгүй байхгүй
- Өмнөдэлгэр сумын ЗДТГ-ын дарга ээлжийн амралтаа биеээр эдлээгүй 663,7 мянган төгрөгийн цалинг давхардуулан авсан, зайлшгүй шаардлагаар ажилд оруулах болон нөхөн амраах тушаал шийдвэр гараагүй

Тогтмол зардлуудыг шууд зардалд хаасан зөрчлийн талаар

- АДБ Хан Хэнтий Чуулга 703,2 мянган төгрөгийн, Дадал сумын ЗДТГ 16316,7 мянган төгрөгийн тогтмол зардлыг шууд зардалд
- Жаргалтхаан сумын сургууль 48311,5 мянган төгрөгийн, цэцэрлэг 17366,7 мянган төгрөгийн, Өмнөдэлгэр сумын сургууль 86303,7 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд зардалд тус тус хаасан

Шуудан холбооны зардалын талаар

- Шуудан холбооны хэмнэгдсэн зардлаас ажилчдын нэр дээр бүртгэлтэй үүрэн телефоны нэгжийн болон сунгалтын төлбөрт Аймгийн ИТХ 485,0 мянган төгрөгийг, ЗДТГазар 2755,0 мянган төгрөгийг, ОНӨАлба 115,0 мянган төгрөгийг, ХАААлба 265,0 мянган төгрөгийг, Дэлгэрхаан сумын ЗДТГ 280,0 мянган төгрөгийг, Өмнөдэлгэр сумын ЗДТГ 1558,0 мянган төгрөгийг, ИТХ 54,0 мянган төгрөгийг буюу нийт 5512,0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн нь

“Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтын жагсаалт, зардлын нормативыг батлах тухай” Засгийн газрын 1999 оны 84-р тогтоолыг зөчсөн бөгөөд тогтоолын 1-р хавсралтаар “Засгийн газар, зарим агенлагуудын үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг”, 2-р хавсралтаар “Нийслэл, зарим аймгийн засаг дарга, түүний харъяа байгууллагуудын үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг” баталсан байдаг.

Энэ тогтоолын зардлын норматив батлагдаад 17 жил болсон мөн Орон нутагт онцгой нөхцөл байдлын улмаас хэрэглэгдэх утасны нэгжийн төлбөр зайлшгүй шаардлагатай байдлыг харгалзан үзэж тогтоолд тодорхой өөрчлөлт оруулах тухай саналыг Монгол улсын Засгийн газарт хүргүүлэхийг Үндэсний аудитын газарт уламжилж байна.

- DDISH телевизийн сунгалтын төлбөрт Дадал сумын ИТХ 65,0 мянган төгрөгийг, Өмнөдэлгэр сумын ЗДТГ 126,0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн

Аймгийн аудитын газраас 180,3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан, 36,5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, 9,5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 197,4 сая төгрөгийн зөрчилийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан байна.

12.4 Хуримтлагдсан үр дүнгийн талаар

2015 оны Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн 6489,3 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 39853,2 сая төгрөг болсон байна.

12.5 Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланг мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, зардалын дүнгээр 2015 оны эцэсийн үлдэгдэлийг тулган баталгаажуулахад Аймгийн ИТХ-ын санхүүгийн тайлалд тусгагдсан 26,1 сая төгрөгийн бусад авлагыг нэгтгэсэн тайланд тусгаагүй мөн Бэрх тосгоны төрийн сангийн харилцахын үлдэгдэл 1 төгрөгөөр, Норовлин сумын төрийн сангийн харилцах 0,50 мөнгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Арван тав. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 131, тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага 112, халамжийн сан, ОНХСан 23, төсөл сан 75, төрийн сангийн нэгж 22, орон нутгийн өмчит 34 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Үүнээс:

- ✓ Төсөл сан -1
- ✓ Орон нутгийн төсөвт байгууллага 7
- ✓ ОНӨҮГазар-4
- ✓ Тусгай шилжүүлэг-38
- ✓ Сумын ТТЗ буюу төрийн сангийн нэгж-13 буюу нийт 63 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийсний 41 хувь буюу 26 нэгжид аймгийн Аудитын газар, үлдэх 59 хувь буюу 37 нэгжид хувийн аудитын компани аудитыг тус тус хийсэн байна.

Аймгийн аудитын газраас Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийж 816,7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 281,1 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 283,4 сая төгрөгийн материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 124 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар Хэнтий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага, сумдын ТЕЗ-ийн нийт 63 санхүүгийн тайланд хийсэн аудитаар 53 тайланд зөрчилгүй, 8 тайланд хязгаарлалттай, 2

тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Аудитаар 12,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 239,7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн зарим батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн зарим ТШЗ, сумдын ТЕЗахирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэлээ. Үүнд:

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан Хэнтий аймгийн ТШЗ, ТТЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Аймгийн ЗДТГ	➤ 2015 оны өөрийн орлогын төлөвлөгөөг 1523.6 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн буюу түрээсийн орлогыг 577.8 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, ➤ Засаг даргын нөөц сангаас зарцуулсан 265.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, 124.1 мянган төгрөгийг анхан шатны үндсэн баримтгүйгээр олгосон, ➤ 238.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, ➤ 1082.0 мянган төгрөгийн зарцуулалтын тайлан дутуу, 10000.0 мянган төгрөгийн зарцуулалтын тайлан байхгүй байна. ➤ Шинэ жилийн баярын арга хэмжээнд 670.0 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан. ➤ 16 нэр төрлийн 11835.9 мянган төгрөгийн бараа материалыг 2 нэр төрлийн 2441.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг анхан шатны баримтгүй болон тушаал шийдвэргүйгээр данснаас хассан байна. ➤ Тайлант онд хувь хүнд цалингийн урьдчилгааг 33.0 мянган төгрөгөөр, гарт олгох цалинг 4.4 мянган төгрөгөөр, НДШимтгэлийг 60.7 мянган төгрөгөөр, ХХОАТатварыг 116.5 мянган төгрөгөөр илүү, цалингаас суутгасан 272.9 мянган төгрөгийн бусад суутгалыг шилжүүлээгүйг санхүүгийн тайланд өглөг, авлага үүсгээгүй, ➤ мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлыг 2872.5 мянган төгрөгөөр дутуу, НДШимтгэлийн зардлыг 2872.5 мянган төгрөгөөр илүү тусгасан. ➤ Байгууллагын бүх албан хаагчдын хувийн үүрэн телефоны ярианы төлбөрт байгууллагын төсвөөс 2755.0 мянган төгрөгийн нэгж олгосон зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.
2	Аймгийн ИТХ	➤ Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлаас нийт 19000.0 мянган төгрөг, бэлэн мөнгөөр нийт 3650.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг анхан шатны баримтгүй зарцуулж, бүртгэл тайланд тусгасан, ➤ Бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 47748.4 мянган төгрөг, албан томилолтын зардлаас нийт 963.5 мянган төгрөгийн анхан шатны хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж, бүртгэл тайланд тусгасан, ➤ Ажилчдын нэр дээр бүртгэлтэй үүрэн телефоны ярианы төлбөрт байгууллагын төсвөөс нийт 485.0

		мянган төгрөг төлсөн, нийт 158.5 мянган төгрөгийн албан томилолт илүү олгосон алдаа, зөрчил илэрлээ
3	БОАЖГазар	➤ НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулаагүй. ➤ 2015 оны санхүүгийн тайланд бүртгэсэн 4155.0 мянган төгрөгийн авлага 6545.0 мянган төгрөгийн өглөгийн тооцоог харилцагч аж ахуй нэгж байгууллагатай нийлж баталгаажуулаагүй ➤ Санхүүгийн тайланд тусгагдсан 106651.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө, 32602.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй няравын дэлгэрэнгүй тайланг гаргаагүй, аудитад ирүүлсэн бараа материалын тайлангийн орлого зарлагын баримтанд гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэгээр баталгаажуулаагүй хүчин төгөлдөр бус баримтыг ирүүлсэн тул тулган шалгах боломжгүй байлаа. ➤ Мөн хөрөнгийн тооллогыг хийгээгүй ➤ 2015 оны 7,8,9,10-р саруудад 26 албан хаагчдад хоолны мөнгийг бодож олгохдоо 926,5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон зэрэг алдаа зөрчил илэрсэн байна
4	Жаргалтхаан сум ЭМТ	➤ Шагнал урамшууллын зардалд 45.0 мянган төгрөг, эмний зардалд 1208.0 мянган төгрөг, хөтөлбөр арга хэмжээний зардалд 179.9 мянган төгрөг, хоолны зардалд 24.5 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 159.8 мянган төгрөг, нийт 1617.2 мянган төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан, ➤ Тээвэр шатахууны зардалд 8126.3 мянган төгрөгийг шаардах хуудасгүй, 599.1 мянган төгрөгийг замын хуудасгүй буюу бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлагдсан, ➤ Ажиллагсдын цалингаас суутгасан 16787.0 мян.төгрөгийн НДШимтгэлийг НДШ-ийн өглөг дансанд , цалингаас суутгасан 13404.3 мянган төгрөгийн ХХОАТатварыг өглөгийн дансанд бүртгээгүй, харилцахаас шууд зардалд бүртгэсэн зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн
5	Жаргалтхаан сум ЕБС	➤ Хоолны материал худалдан авахад бүрдэл дутуу анхан шатны баримтаар 718.6 мянган төгрөгийг зарлагдсан, 150.0 мянган төгрөгийн малын хорогдлыг үхсэн хорогдсон малын актгүй буюу анхан шатны баримтгүй гүйлгээг данс бүртгэлд бүртгэсэн, ➤ Ажиллагсдад олгосон 5313.6 мянган төгрөгийн цалингаас 184.8 мянган төгрөгийн НДШимтгэлийг дутуу суутгасан, ажиллагсдын цалингаас суутгасан 27201.7 мян.төгрөгийн НДШимтгэлийг НДШ-ийн өглөг дансанд , цалингаас суутгасан 21109.8 мянган төгрөгийн ХХОАТатварыг өглөгийн дансанд бүртгээгүй, харилцахаас шууд зардалд бүртгэсэн, ажиллагсдад олгосон 3204.3 мянган төгрөгийн цалинг НДаатгалын тайланд тайлагнаагүйгээс, ➤ НДШимтгэлийн өглөгийг 676.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, ажиллагсдад олгосон 170.0 төгрөгийн

		цалингийн урьдчилгааг суутгаагүй байсныг авлагын дансанд бүртгээгүй, ➤ олгосон урьдчилгаанаас 100.0 мянган төгрөгийг илүү суутгасныг өглөгийн дансанд бүртгээгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн.
6	Жаргалтхаан сум Цэцэрлэг	➤ Эм тариа худалдан авахад 13.5 мянган төгрөг, цалингийн зардалд 151.6 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 732.5 мянган төгрөгийг шаардах хуудасгүй, 28.4 мянган төгрөгийг замын хуудасгүй буюу бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлагдсан, ➤ Ажиллагсдын цалингаас суутгасан 9874.7 мян.төгрөгийн НДШимтгэлийг НДШ-ийн өглөг дансанд, цалингаас суутгасан 7492.0 мянган төгрөгийн ХХОАТатварыг өглөгийн дансанд бүртгээгүй, харилцахаас шууд зардалд бүртгэсэн зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн
7	Өмнөдэлгэр сум ЭМТ	➤ 1125.0 мянган төгрөгийн малыг анхан шатны баримтгүй зарлагдсан, ➤ Тээвэр шатахууны зардалд 185.0 мянган төгрөгийг шаардах, замын хуудасгүй зарлагдсан, ➤ 2564.6 мянган төгрөгийн эм тариаг нягтлан бодогч НББүртгэлд бараа материалын орлогод бүртгэсэн боловч сувилагч Ц.Дэнсмаагаар бэлтгүүлсэн эмийн тайланд тайлагнаагүй, ахлах сувилагч Ц.Хоролсүрэн эмийн тайланг гаргадаггүй, ➤ Ажиллагсдад олгосон 4193.8 мянган төгрөгийн цалинг НДаатгалын тайланд тайлагнаагүйгээс, НДШимтгэлийн өглөг 880.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, ажиллагсдын цалингаас суутгасан 186.7 мянган төгрөгийн ХХОАТатварын өглөгийг төлж барагдуулаагүйг өглөгийн дансанд бүртгээгүй зэрэг зөрчил илэрсэн
8	Баянмөнх сум ТТЗ	ЗДТГазар: • 2015 оны санхүүгийн тайланд тусгасан 625.7 мянган төгрөгийн авлагыг тооцоог харилцагч аж ахуй нэгж байгууллагатай нийлж баталгаажуулаагүй. • 2015 онд 400.0 мянган төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас 52.0 мянган төгрөгийг орлогод төвлөрүүлж, 348.0 мянган төгрөг буюу 87 хувиар дутуу биелүүлсэн. ИТХурал: • Тайлант оны төсвийн төвлөрүүлсэн үлдэгдэл 1944.8 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасаж илэрхийлээгүй. Соёлын төв: • Цалингаас суутгасан даатгуулагчаас төлөх НДШимтгэлийг 47.8 мянган төгрөгөөр дутуу төлж, санхүүгийн тайланд өглөг үүсгээгүй. • Тайлант оны төсвийн төвлөрүүлсэн үлдэгдэл 150.3 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасаж илэрхийлээгүй.

	- Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнг орлого үр дүнгийн тайланд 392.7 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, үйл ажиллагааны нийт үр дүнг 392.7 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан. Эрүүл мэндийн төв: - Нэмэлт данснаас малчны цалинд 1799.7 мянган төгрөгийг олгохдоо даатгуулагчаас суутгах 179.9 мянган төгрөг, байгууллагаас төлөх 198.0 мянган төгрөг нийт 377.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоогүй. - Нэг удаагийн тэтгэмж болох 101.0 мянган төгрөгөөс ХХОАТатвар тооцсон. - Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо байгууллага нь Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 297 тоот тогтоолоор хүчингүй болсон 233-р тогтоолыг баримталсан. ЕБСургууль: - Тайлант жилд нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн программаар хөтөлж тайланг гаргасан боловч санхүүгийн тайлан бүхэлдээ буруу гарсан. Баланс 14.8 мянган төгрөгөөр, санхүүгийн тайланг мөнгөн гүйлгээний тайлангаас хөөн шалгахад 6,799.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, үр дүнгийн тайланд хандив тусламжийн орлого 173,547.4 мянган төгрөгийг тусгаагүй, олгохоор тооцсон цалинг 13788.1 мянган төгрөгөөр илүү, нийгмийн даатгалын шимтгэлийг 8,182.9 мянган төгрөгөөр илүү, бараа материалын зардлыг 169.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан, мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын нийт дүнг 500.0 мянган төгрөгөөр дутуу, цалин, шимтгэлийн зардлыг 13315.2 мянган төгрөгөөр илүү тусгасан. 2015 оны 1-11 дүгээр сард дотуур байрны хүнсний материалын тайланд хүүхдийн тоо байхгүй материалын орц норм хэтэрхий бага байдалтай, 12 дугаар сард 41-43 хүүхдэд нэг хүүхдийн өдрийн хоолны зардлыг хэт бага 901 төгрөгөөс 1400 төгрөгөөр буюу махны норм 10,3 кг байхыг 3.5 кг-аар, гурилыг 4.5 кг-аар тооцож олгохыг 1.5 кг-аар зарлагадсан тайлан гарсныг сургуулийн захирал, нягтлан бодогч нар баталгаажуулсан. - Түлш шатах тослох материалын зардлаас түлээ нүүрс авч орлого зарлагын хамт бүртгэсэн, 993.8 мянган төгрөгийн бензин маслыг жолоочийн тооцооны хуудасгүй шаардах хуудсаар зарцуулсан. - Ажилтанд олгосон 350.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжээс ХХОАТ тооцсон. - Тайлант оны эцэст Нийгмийн даатгалын байцаагчтай тооцоо нийлсэн актаар шимтгэлийн 1300.5 мянган төгрөгийн авлагатай гарсныг санхүүгийн тайланд тусгаагүй ба аудитын явцад баримтаар тулгахад энэ авлага баталгаажихгүй байсан. Цэцэрлэг: - Тайлант жилд нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн программаар хөтөлж тайланг гаргасан боловч санхүүгийн тайлан бүхэлдээ буруу гарсан. Баланс 27.9 мянган төгрөгөөр, санхүүгийн тайланг мөнгөн гүйлгээний тайлангаас хөөн шалгахад 338.4 мянган төгрөгөөр
--	--

		зөрүүтэй, үр дүнгийн тайланд цалин, шимтгэлийн зардлыг зөрүүлж нийгмийн даатгалын шимтгэлийг 8182.9 илүү, цалин зардлыг мөнгөн гүйлгээний тайлангаас 8235.9 мянган төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд нийт зардлыг харилцах дансны зарлагаас 214.2 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Нийгмийн даатгалын байгууллагад гаргасан тайлангаас 363.1 мянган төгрөгөөр илүү тусгасан. • Түлш шатах тослох материалын дансанд түлээ нүүрсний орлого зарлагыг бүртгэж тайлан гаргасан нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн дансны заавар”-ыг зөрчсөн. • Ажилтанд олгосон 259.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжээс 25.9 мянган төгрөгийн ХХОАТ тооцсон. • Тайлант оны эцэст Нийгмийн даатгалын байцаагчтай тооцоо нийлсэн актаар 719.7 мянган төгрөгийн шимтгэлийн авлага, 37.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг алдаа зөрчил илэрсэн байна.
--	--	--

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийн шалтгаан
1	Баянмөнх сум Цэцэрлэг	➢ Цэцэрлэгийн 2015 оны санхүүгийн тайлан мэдээ бүхэлдээ буруу гарсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж ажиллаагүй, ➢ Нийгмийн даатгал, татварын байгууллагатай тооцоо нийлсэн актаар гарсан өглөг, авлагыг данс бүртгэл болон тайланд үнэн зөв тусгаагүй, ➢ Ажилтанд олгосон буцалтгүй тусламжаас ХХОАТ тооцсон, санхүүгийн баримт материал, тайланг аудитын байгууллагад ирүүлэх хуулийн хугацааг хоцроож, 2-р сарын 25-наас хойш ирүүлсэн, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй гүйцэтгэсэн зэрэг алдаа зөрчил гарсан
2	Баянмөнх сум ЕБС	➢ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж мөрдөөгүй, ➢ 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан бүхэлдээ буруу гарсан, дотуур байрны сурагчдын хоол хүнсэнд мах, гурилыг тогтоосон нормоос 3 дахин бага олгосон, ➢ 2015 оны 1 дүгээр сараас 11 сар хүртэлх хугацааны хүнсний материалын тайланд хүүхдийн тоо бичилгүйгээр материалыг зарлагадсан нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэхийг шалгах боломжгүй болгосон, ➢ 993.8 мянган төгрөгийн шатах тослох материалыг анхан шатны баримтгүй буюу жолоочийн тооцооны хуудасгүйгээр зарлагадсан, ➢ НДШ-ийн тооцоо нийлсэн актаар 1300.5 мянган төгрөгийн авлагатай гарсан, авлага өглөгийг НББ

		болон санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй, санхүүгийн баримт материал, тайланг аудитын байгууллагад ирүүлэх хуулийн хугацааг хоцроож, 2-р сарын 25-наас хойш ирүүлсэн, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй гүйцэтгэсэн зэрэг алдаа зөрчил илэрсэн.
--	--	--

Арван зургаа. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2015 оны үр дүнгийн тайланд нэгтгэсэн нийт зардлыг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 1.0 хувиар сонгон 953,3 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 816,7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн тул Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгч байна. Зөрчлийг ангилавал:

- Мөнгөн хөрөнгийн дансанд буюу зарцуулахтай холбоотой илэрсэн 37,8 сая төгрөгийн зөрчил
- Авлагатай холбоотой 55,8 сая төгрөгийн
- Бараа материалын дансны бүртгэл, зарцуулахтай холбоотой 46,9 сая төгрөгийн
- Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 183,1 сая төгрөгийн
- Өр, төлбөрийн бүртгэлтэй холбоотой 41,8 сая төгрөгийн
- Орлогын бүртгэлтэй 51,2 сая төгрөгийн
- Зардлын данс буюу зарцуулахтай холбоотой 423,6 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн байна.

Арван долоо. Тайлант оны аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Хэнтий аймгийн ЗДТГ-ын СТСангийн хэлтэст:

1. Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аймгийн ИТХ-ын нэмэлт данснаас төвлөрүүлсэн 26.1 сая төгрөгийн авлагыг нэгтгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, Үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 26,1 сая төгрөгийн авлагыг тусгаж залруулах

2. Аудитаар зардалтай холбоотой 423.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 51.8 хувийг буюу ихэнх эзэлж байна. Үүнд: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийх, НДШ, ХХОАТ-ын өглөг болон бусад тогтмол зардлуудыг шууд зардалд

хаах, зардыг зориулалт бусаар зарцуулах, шийдвэр, захирамжгүйгээр зардал гаргах зэрэг зөрчлүүд эзэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалтууд, УСНББОУС-1, Иж бүрэн байх, толилуулга, үнэлгээ, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй, СС-ын 2006 оны 388-р тушаалын 1-р хавсралтаар баталсан НББ-ийн зааврын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар гарсан дээрх нийтлэг зөрчлийг арилгах талаар аймгийн СТСангийн хэлтэсээс сумдын санхүүгийн алба, нягтлан бодогч нарт мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

3. 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Аймгийн ТЕЗ-д нэгтгэгддэг байгууллагуудад хууль тогтоомж, журам зааварыг зөрчсөн алдаа нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй байна. Үүнд:

- Бодлогын бичиг баримт боловсруулж батлаагүй, бодлогын бичиг баримтандаа бүртгэлтэй холбоотой Сангийн сайдын шинэ тушаал шийдвэрийг тусгаагүй
- Хүчингүй болсон журмыг баримтлаж үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу тооцоолсон,
- Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 2-р хавсралтаар батлагдсан зааврын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгын бэлтгэж тайлагнаагүй
- ЗГ-ын 2012 оны 106 тоот тогтоолоор батлагдсан "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" журмыг цэцэрлэг, сургуулиуд мөрдөж ажиллаагүй
- "Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт батлах тухай" ЗГ-ын 1999 оны 84-р тогтоолыг зөрчиж утасны төлбөр төсвийн хөрөнгөөр төлөх зөрчил нийтлэг байна.

Шийдвэрлэсэн нь:

- ✓ ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын нягтлан бодогч нарыг шинэчилэн найруулсан, хүчингүй болсон хууль тогтоомж, журам заавар болон УСНББОУС-тай холбоотой ном, материалаар хангаж, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
- ✓ Сангийн сайдын 388-р тушаалын дагуу жилийн эцэсийн тайланг авах нэгтгэхдээ санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгүүлж авах, мөн касс, харилцах, өглөг авлагын дансанд тусгагдсан үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байдлыг хянаж, тулгаж авах
- ✓ Засгийн газрын 1999 оны 84-р тогтоолыг зөрчихгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн дэргэдэх СХААлбанд:

1. Аудитаар нийт 816.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлтэй, тайлагналттай холбоотой 183.1 сая төгрөгийн буюу нийт зөрчлийн 22.4 хувийг эзэлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.1-д “Эд хөрөнгийн тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хариуцна”, 11.2.1-д “Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллого хийнэ”, 19.1.4-д “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх” гэсэн

заалтыг зөрчиж, толилуулга, оршин байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг байгууллагуудаас илэрсэн үндсэн хөрөнгө, түүний тооллого, тооллогын чанартай холбоотой зөрчлийг арилгуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд

Аудит хийсэн багийн гишүүд:

Ахлах аудитор

Х.Еркегүл

Шинжээч

М.Чулуун-Эрдэнэ

ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Ж.ОЮУНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харъяа Хэнтий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Аймгийн ТЕЗ нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн туулийн 54 дэхь заалт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн ТЕЗ-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ТЕЗ-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ЭНХТҮВШИН

